

## ӨНДӨРХААН ХК-ИЙН 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ

### 1. Компанийн бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Өндөрхаан ХК нь анх 1992 онд өмч хувьчлалаар үүсгэн байгуулагдсан бөгөөд Хэнтий аймгийн “Өндөрхаан” сангийн аж ахуйг аймгийн өмч хувьчлалын комиссоос гурван хувьцаат компани болгон өөрчлөн байгуулсны нэг юм. Үүсгэн байгуулагдснаас хойш Өндөрхаан ХК нь мал аж ахуй, газар тариалан, төмс, хүнсний ногоо тариалах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байсан. Гэвч, хөдөө аж ахуйн салбарт тулгарч байсан байгалийн таагүй нөхцөл байдал болон технологийн хоцрогдол зэргээс үүдэн Өндөрхаан ХК нь санхүүгийн хүндрэлтэй байдалд орж, хөрөнгө мөнгөгүй болсны улмаас 2012 оноос хойш үндсэн үйл ажиллагаагаа явуулаагүй.

Тиймээс, компани цаашид үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхийн тулд хэвийн ажиллаж буй компанийг нэгтгэхээр шийдсэн ба 2017 оны 10-р сарын 16-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар Тэмүүжин хүнс ХХК-ийг өөртөө нэгтгэж, үйл ажиллагааны чиглэл хүрээгээ тэлж, шинэ хөрөнгө оруулалт татаж, өөрчлөн байгуулагдах тухай асуудлыг хэлэлцэн, Нэгтгэх гэрээ журмыг урьдчилсан байдлаар баталсан юм. Компани Тэмүүжин хүнс ХХК-ийг өөртөө нэгтгэснээр цаашид үйл ажиллагаа өргөжүүлэн явуулах боломжтой ба хувьцааны үр өгөөж, хөрвөх чадварыг нэмэгдүүлж, одоогийн хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг хамгаална.

2017 онд компани нэгтгэж өөрчлөн байгуулахтай холбоотой хөрөнгийн үнэлгээ, аудитыг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагуудаар хийлгэсэн. Мөн, 2017 оны 11-р сард компанийн гүйцэтгэх захирлыг өөрчилж, Тэмүүжин хүнс ХХК-ийн хүсэлтийг үндэслэн Хорлоогийн Баатархүүг томилон ажиллуулж байна. Компанийн хөрөнгийн үнэлгээг 2017 оны 8-р сарын 31-ний байдлаар Оюу-Эрдэм Аудит ХХК-аар хийлгэсэн ба хөндлөнгийн үнэлгээчид Өндөрхаан ХК-ийн нэгж хувьцааны бодит үнэ цэнийг 310 төгрөгөөр тогтоосон. Төлөвлөгөө ёсоор бид 2017 ондоо багтааж Тэмүүжин хүнс ХХК-ийг нэгтгэх танилцуулга материалыг СЗХ болон МХБ-д өгөх ёстой байсан боловч Тэмүүжин хүнс ХХК дээр дотоод асуудал гарсан тул хойшлогдсон болно.

### Нэгдэж буй компани - Тэмүүжин хүнс ХХК-ийн тухай товч танилцуулга

Тэмүүжин хүнс ХХК нь 2014 онд гадаад худалдаа, газар тариалан, мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар үүсгэн байгуулагдсан бөгөөд байгуулагдсан цагаасаа хойш газар тариалангийн чиглэлээр эрчимжүүлсэн газар тариалан эрхлэхэд тохиромжтой бүс нутгуудад газар эзэмших эрх олж авах чиглэлд идэвхийлэн ажилласан байна. Мөн цаашид санхүү, мэдээллийн технологи, аялал жуулчлал зэрэг салбаруудад хөрөнгө оруулах, олон улсын зах зээл рүү гарах хэтийн зорилготой ажиллаж буй юм.

Үүний үр дүнд Төв аймгийн Сэргэлэн, Баяндэлгэр сумдуудад нийт 728 га газар эзэмших эрхтэй болсон ба цаашид тохиромжтой хэмжээнд хүрсэн нөхцөлд тариалалтаа эхлэхээр төлөвлөн ажиллаж байна. Компани өөрийн эзэмшлийн 728 га талбайд ирэх жилээс тариалалт хийхээр төлөвлөж байгаа бөгөөд 2500 орчим тонн үр тариа хүлээн авах зорилттой байна. Цаашид үр тариалангийн аж ахуйг илүү эрчимжүүлж, усалгаатай болгох, нэгж талбайгаас авах бүтээгдэхүүний үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллахаар төлөвлөж байна. Ингэснээр байгалийн хүчин зүйлээс хамаарах эрсдэл буурч, үр ашигт байдал илүү тогтвортой болох юм.

### Тэмүүжин хүнс ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц:

№	Хувьцаа эзэмшигчид	Хувьцааны тоо ширхэг	Нэрлэсэн үнэ, ₮	Хувь нийлүүлсэн хөрөнгө	
				Төгрөг	Эзлэх хувь
1	Глобал лайф ХХК	15,200	100,000	1,520,000,000	95%
2	Х.Баатархүү	800	100,000	80,000,000	5%
Нийт дүн		16,000		1,600,000,000	100%

Нэгдэж буй Тэмүүжин хүнс ХХК нь компанийн нэгдэлд хамаардаг ба толгой компани нь гадаадын хөрөнгө оруулалттай Глобал лайф ХХК бөгөөд тус компани нь Тэмүүжин хүнс ХХК-ийн нийт хувьцааны 95%-ийг эзэмшдэг. Глобал лайф ХХК нь 2014 онд байгуулагдсан бөгөөд гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Түүнчлэн, Тэмүүжин хүнс ХХК нь Ирээдүй финанс ББСБ-ийн хувьцааны 50%-ийг эзэмшихээр 2017 онд хөрөнгө оруулалт хийсэн байна.

## 2. Удирдлагын талаарх мэдээлэл

Өндөрхаан ХК-ийн гүйцэтгэх захирлаар Монгол Улсын иргэн Х.Баатархүү 2017 оны 11-р сараас ажиллаж байна. Х.Баатархүү нь 1978 онд Өмнөговь аймагт төрж өссөн, одоогоор эхнэр хүүхдийн хамт Улаанбаатар хотод ажиллаж амьдардаг. Тэрээр Бээжин хот дахь Санхүү, Эдийн Засгийн Их Сургуулийг санхүү, эдийн засгийн мэргэжлээр төгссөн, хятад хэлтэй ба хятадын түүх, улс төр, санхүү, эдийн засгийн талаар сонирхон судалдаг.

## 3. Санхүүгийн байдлын талаарх мэдээлэл

Санхүүгийн байдлын хувьд 2017 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар нийт хөрөнгө 34,509,800 төгрөг, ямар нэгэн өр төлбөргүй, эздийн өмч 34,509,800 төгрөг, хуримтлагдсан алдагдал 11,963,200 төгрөг байна. 2017 онд үйл ажиллагаа явуулаагүй учраас борлуулалтын орлого олоогүй, үйл ажиллагааны зардал 1,025,500 төгрөг гарсан нь аудитын зардал, гишүүнчлэлийн хураамж байсан ба 19,755,300 төгрөгийн найдваргүй авлагыг хааж, 15,146,200 төгрөгийн бараа материал акталсан. 2017 оны санхүүгийн тайланд Сүлд-Аудит ХХК-аар аудит хийлгэж, дүгнэлт гаргуулсан.

## 4. Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл

Хувьцаа эзэмшигч Л.Золбаяр нь компанийн нийт гаргасан хувьцааны 81.73% буюу 91,443 ширхгийг эзэмшдэг. Үлдсэн 18.27%-ийг 298 жижиг хувьцаа эзэмшигч эзэмшиж байна.

Өндөрхаан ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц:

№	Хувьцаа эзэмшигчид	Хувьцааны тоо ширхэг	Нэрлэсэн үнэ, ₮	Хувь нийлүүлсэн хөрөнгө	
				Төгрөг	Эзлэх хувь
1	Л.Золбаяр	91,443	100	9,144,300	81.73%
2	Бусад 298 хувьцаа эзэмшигч	20,436	100	2,043,600	18.27%
Нийт дүн		Нийт дүн		11,187,900	100%

## 5. Ногдол ашигийн талаарх мэдээлэл

Компани 2017 онд үндсэн үйл ажиллагаа явуулаагүй тул ногдол ашиг тараах боломжгүй.

## 6. Бусад шаардлагатай мэдээлэл

2018 онд Өндөрхаан ХК-д Тэмүүжин хүнс ХХК-ийг нэгтгэх үйл ажиллагааг үргэлжлүүлэн, амжилттай гүйцэтгэж дуусгах төлөвлөгөөтэй ажиллана. Үүнд 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэр, мөн Өндөрхаан ХК-ийн 2017 оны 10-р сарын 16-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас баталсан Нэгтгэх гэрээ, журам болон хурлаас гарсан тогтоол шийдвэр дээр үндэслэн ажиллана.